

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэний агаарын хөлгөөр нислэг үйлдэх, нисэхийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Иргэний нисэхийн тухай хууль тогтоомж

2.1.Иргэний нисэхийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэрт нислэг үйлдэхтэй холбогдсон дараах харилцааг зохицуулна:

3.1.1.Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагаа;

3.1.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлаж байгаа, эсхүл агаарын зайд нислэг үйлдэж байгаа иргэний агаарын хөлгийн үйл ажиллагаа;

3.1.3.Гадаад улсын хуульд өөрөөр заагаагүй бол тухайн улсын нутаг дэвсгэрт байрлаж байгаа Монгол Улсын бүртгэлтэй, эсхүл Монгол Улсын агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгийн үйл ажиллагаа;

3.2.Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэж байгаа улсын агаарын хөлгийн байлдааны үүргийн нислэгээс бусад нислэгийн хөдөлгөөнийг удирдахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл.Иргэний нисэхийн үйл ажиллагаанд баримтлах зарчим

4.1.Иргэний нисэхийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

4.1.1.аюулгүй;

4.1.2.үр ашигтай;

4.1.3.хүртээмжтэй;

5 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

5.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1.“агаарын зай” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрээс дээших хийн мандлын агаарын давхаргын орон зайг;

5.1.2.“агаарын навигацийн үйлчилгээ” гэж агаарын зайд үйлдэгдэж байгаа нислэгийн бүх үе шатанд үзүүлэх нислэгийн хөдөлгөөний менежмент, холбоо, навигаци, ажиглалт, нисэхийн мэдээлэл, нисэхийн цаг уурын үйлчилгээ болон эрэн хайх, авран туслах үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл дамжуулах, тэдгээрийг багтаасан цогц үйл ажиллагаа;

5.1.3.“агаарын навигацийн байгууламж” гэж агаарын навигацийн үйлчилгээнд ашиглагдах барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг;

5.1.4.“агаарын тээвэрлэгч” гэж иргэний нисэхийн дүрмийн дагуу олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээдийг;

5.1.5.“агаарын хөлөг” гэж агаар газрын гадаргуутай харилцан үйлчилснээс өөр, агаарын урсгалын харилцан үйлчлэлээр агаар мандалд хөөрөн нисэх чадвартай төхөөрөмжийг;

5.1.6.“аюулгүй байдлын зөвлөмж” гэж шинжлэн шалгах ажиллагааны үр дүнд, эсхүл аюулгүй байдлын талаар гаргасан судалгаа болон бусад эх үүсвэрийг үндэслэн агаарын хөлгийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах эрх бүхий байгууллагаас гаргасан саналыг;

5.1.7.“аэродром” гэж агаарын хөлгийн хөөрөлт, буулт болон гадаргуу дээрх хөдөлгөөнд бүхэлдээ эсхүл хэсэгчлэн ашиглахад зориулсан газар, усан дээр тогтоосон талбай болон түүн дээрх барилга, байгууламж, тоног төхөөрөмжүүдийг;

5.1.8. “зөрчил” гэж агаарын хөлгийн аюулгүй байдалд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болох, ослоос бусад эрсдэл бүхий тохиолдлыг;

5.1.9.“иргэний нисэхийн дүрэм” гэж Олон улсын иргэний нисэхийн тухай “Чикагогийн конвенц” /цаашид “Конвенц” гэх/, түүний Хавсралтын стандартын суурь түвшнийг хангах зорилгоор энэ хуульд нийцүүлэн гаргасан нисэхийн аюулгүй байдлын зохицуулалтын баримт бичгийг;

5.1.10.“нислэг” гэж агаарын хөлөг нислэг үйлдэх зорилгоор зогсоолоос хөдлөхөөс эхлэн хөөрөх, газарт бууж хөдөлгөөнөө бүрэн зогсоох хүртэлх үйл явцыг;

5.1.11.“нислэгийн аюулгүй байдал” гэж нислэгийн үйл ажиллагаа болон түүнд хамаарах бусад үйл ажиллагааг хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд хохирол учруулахгүйгээр гүйцэтгэх нөхцөл байдал болон чадварыг;

5.1.12.“нислэгт тэнцэх чадвар” гэж агаарын хөлөг, түүний бүрдэл хэсэг нислэгийн аюулгүй байдлын шаардлагад нийцэж байгаа төлөв байдлыг;

5.1.13. “нисэхийн аюулгүй байдал” гэж агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой, эсхүл түүнд шууд дэмжлэг үзүүлдэг нисэхийн үйл ажиллагаанд хамаарах эрсдэлийг хүлээн зөвшөөрөгдөхүйц түвшинд хадгалах ба удирдах нисэхийн байгууллага, эсхүл тогтолцооны төлөв байдлыг;

5.1.14. “нисэхийн аюулгүйн хамгаалалт” гэж хүний нөөц болон материаллаг эх үүсвэрийг хослуулах замаар иргэний нисэхийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах цогц үйл ажиллагаа;

5.1.15. “нисэхийн мэргэшсэн ажилтан” гэж иргэний нисэхийн дүрмийн дагуу олгосон үнэмлэх, гэрчилгээ эзэмшигчийг;

5.1.16. “нисэхийн мэдээллийн эмхэтгэл” гэж тухайн улсаас эсхүл тухайн улсын зөвшөөрлөөр эрхлэн гаргадаг, агаарын навигацид чухал шаардлагатай, тогтмол шинж чанартай нисэхийн мэдээллийг агуулсан хэвлэлийг.

5.1.17. “осол” гэж Чикагогийн конвенцын Хавсралт 13-т зааснаар ойлгоно.

5.1.18. “шинжлэн шалгах” гэж агаарын хөлгийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, нөлөөлсөн хүчин зүйл бүрийг тогтоож, дүгнэлт гарган, аюулгүй байдлын зөвлөмж гаргах үйл ажиллагааг;

ХОЁРДУГААР БҮЛЭГ ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

6 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

6.1. Улсын Их Хурал иргэний нисэхийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;

6.1.2. иргэний нисэхийн тухай хууль тогтоомжийг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

6.1.3. иргэний нисэхийн асуудлаарх олон улсын гэрээнд Монгол Улс нэгдэн орох, гарах асуудлыг шийдвэрлэх;

6.1.4. хуульд заасан бусад.

7 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

7.1. Засгийн газар иргэний нисэхийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1. иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх талаарх төрийн бодлого, иргэний нисэхийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

7.1.2.хууль тогтоомжид заасны дагуу Засгийн газар хоорондын агаарын харилцааны олон улсын гэрээ байгуулах;

7.1.3.олон улсын гэрээ, хууль тогтоомжид нийцүүлэн иргэний нисэхийн аюулгүй байдлын, нисэхийн аюулгүйн хамгаалалтын болон агаарын тээврийг хялбаршуулах журмыг батлах;

7.1.4.олон улсын нисэх буудал байгуулах, татан буулгах асуудлыг шийдвэрлэх;

7.1.5.иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргыг томилох, чөлөөлөх;

7.1.6.хуульд заасан бусад.

8 дугаар зүйл.Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

8.1.Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.иргэний нисэхийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;

8.1.2.иргэний нисэхийн салбарт төрөөс баримтлах бодлого боловсруулах;

8.1.3. иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангуулах;

8.1.5.иргэний нисэхийн дүрмийг батлах;

8.1.6.иргэний нисэхийн эдийн засгийн зохицуулалтыг хэрэгжүүлэх, хяналт тавих;

8.1.7.олон улсын хуваарьт нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчийг томилох;

8.1.8. Монгол Улсын хилээр агаарын хөлөг нэвтрэх орох, гарах цэгийг тогтоох;

8.1.9.агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны дүрмийг батлах;

8.1.10.иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны бүтцийг батлах;

8.1.11.агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дарга бөгөөд ерөнхий шинжлэн шалгагчийг томилох, чөлөөлөх;

8.1.12.агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааг шаардлагатай гэж үзвэл гадаад улсын агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн

шалгах эрх бүхий холбогдох байгууллагатай хамтран гүйцэтгэх, эсхүл тухайн байгууллагад хэсэгчлэн болон бүрэн шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх;

8.1.13.агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох;

8.1.14.иргэний нисэхийн хяналтын Улсын ерөнхий байцаагч, иргэний нисэхийн хяналтын байцаагчийн эрх олгох;

8.1.15.хуульд заасан бусад.

9 дүгээр зүйл.Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, түүний чиг үүрэг

9.1.Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага /цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх/ нь иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газрын тохируулагч агентлаг мөн.

9.2.Төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.2.1.Конвенц, түүний Хавсралтад нийцүүлэн иргэний нисэхийн дүрэм боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах, бүртгүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

9.2.2.хэлэлцэн тохирогч улсын иргэний нисэхийн байгууллагатай хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох;

9.2.3.иргэний нисэхийн дүрэм болон Конвенцын Хавсралтын стандарт, журмын зөрүүтэй байдлыг Олон улсын иргэний нисэхийн байгууллагад мэдээлэх;

9.2.4.иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалттай холбоотой өгөгдөл, мэдээлэл цуглуулах, бэлтгэх, солилцох, түгээх, хадгалалт хамгаалалтыг хариуцах, түүнчлэн энэ асуудлаар бусад этгээдтэй хамтран ажиллах.

9.3.төрийн захиргааны байгууллага нь иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын чиг үүргээ хэрэгжүүлэх нэгжүүдтэй байх бөгөөд хяналт, зохицуулалтыг тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, санхүүгийн чадавхтай байна.

10 дугаар зүйл.Төрийн захиргааны байгууллагын дарга, түүний бүрэн эрх

10.1.Төрийн захиргааны байгууллагын дарга бөгөөд иргэний нисэхийн хяналтын Улсын ерөнхий байцаагч /цаашид “Дарга” гэх/ иргэний нисэхийн мэргэжлийн дээд боловсролтой, тухайн салбартаа 15-аас доошгүй жил ажилласан, иргэний нисэхийн хяналтын байцаагчид тавих шаардлагыг хангасан, Монгол Улсын иргэн байна.

10.2.Дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.2.1.иргэний нисэхийн аюулгүй байдлыг хариуцах;

10.2.2.иргэний нисэхийн хяналтын байцаагчийг томилох, чөлөөлөх;

10.2.3.иргэний нисэхийн дүрмийн зөвлөмжийн цуврал, хүсэлт гаргах маягт, бүртгэлийн дэвтэр, техник, технологийн баримт бичгийг батлах, тэдгээрт өөрчлөлт оруулах;

10.2.4.иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, иргэний нисэхийн мэргэшсэн ажилтны үнэмлэх, гэрчилгээ, зэрэглэл олгох;

10.2.5.аюулгүй байдлын зөвлөмжийг үндэслэн агаарын хөлгийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

10.2.6.нислэгийн аюулгүй байдалд нөлөөлөхүйц иргэний нисэхийн дүрмээр зохицуулагдаагүй нөхцөл байдал шинээр үүссэн тохиолдолд тодорхой хугацаатай шийдвэр гаргаж, мэдээлэх;

10.2.7.нислэгт тэнцэх чадвараа алдсан агаарын хөлгийн нислэгийг зогсоох, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

10.2.8.хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд хохирол учруулж болзошгүй тохиолдолд нислэгийг зогсоох хүртэл арга хэмжээг авах;

10.2.9.хууль болон албадан хэрэгжүүлэх дүрмийн дагуу хувь хүн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх, зөвшөөрлийг түдгэлзүүлэх болон хүчингүй болгох арга хэмжээ авах;

10.2.10.аюулгүйн үзлэг, хамгаалалт шаардлагатай нисэх буудал болон агаарын навигацийн байгууламжийн жагсаалтыг батлах;

10.2.11.энэ хуульд заасны дагуу иргэний нисэхийн дүрмийн шаардлагаас чөлөөлөх;

10.2.12.хуульд заасан бусад.

11 дүгээр зүйл.Эрх шилжүүлэх

11.1.Дарга иргэний нисэхийн аюулгүй байдал болон аюулгүйн хамгаалалтад хамаарах үзлэг шалгалт хийх эрхээ иргэний нисэхийн хяналтын байцаагч болон иргэний нисэхийн мэргэшсэн ажилтанд гэрээгээр бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шилжүүлж болно.

11.2.Дарга эрхээ шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

11.3.Эрх шилжүүлэн гүйцэтгүүлэх журмыг Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжид нийцүүлэн иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЗОХИЦУУЛАЛТ

12 дугаар зүйл.Иргэний нисэхийн зохицуулалт

12.1.Иргэний нисэхийн зохицуулалт нь иргэний нисэхийн дүрмийн зохицуулалт, иргэний нисэхийн аюулгүй байдлын зохицуулалт, иргэний нисэхийн эдийн засгийн зохицуулалтаас бүрдэнэ.

13 дугаар зүйл.Иргэний нисэхийн дүрмийн зохицуулалт

13.1.Иргэний нисэхийн дараах үйл ажиллагааг Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрт нийцүүлэн Иргэний нисэхийн дүрмээр зохицуулна.

13.1.1.Иргэний нисэхийн дүрмийн нэр томъёоны тайлбар;

13.1.2.осол, зөрчлийг мэдээлэх болон албадан хэрэгжүүлэх, дүрмийн шаардлагаас чөлөөлөх үйл ажиллагаа;

13.1.3.агаарын хөлөг, бүтээгдэхүүн, эд ангийг гэрчилгээжүүлэх, агаарын хөлгийн бүртгэл, нислэгт тэнцэх чадварын удирдамж болон техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт;

13.1.4.иргэний нисэхийн мэргэшсэн ажилтны үнэмлэх, зэрэглэл, эрүүл мэндийн гэрчилгээжүүлэлт;

13.1.5.агаарын зайг тогтоох, ангилах болон агаарын зайн зохицуулалт;

13.1.6.нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрэм;

13.1.7.аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны нийтлэг зохицуулалт;

13.1.8.хүнгүй агаарын хөлөг, аргамжаат шүхэр болон хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээжүүлэлт;

13.1.9.агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр;

13.1.10.агаарын хөлгөөр аюултай барааг тээвэрлэх болон зохицуулалттай агаарын ачааны байгууллагын гэрчилгээжүүлэлт;

13.1.11.том, дунд, жижиг агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаа болон дотоод, гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт;

13.1.12.нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх, хөдөө аж ахуйн агаарын хөлөг болон чөлөөт нисэхийн үйл ажиллагааны гэрчилгээжүүлэлт;

13.1.13.аэродром байгуулах болон аэродромын үйл ажиллагааны гэрчилгээжүүлэлт;

13.1.14.нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт;

13.1.15.нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээжүүлэлт;

13.1.16.агаарын хөлөг зохион бүтээх, үйлдвэрлэх болон техник үйлчилгээ хийх байгууллагын гэрчилгээжүүлэлт;

13.1.17.шүхэр, хэт хөнгөн агаарын хөлөг болон нисэх клубийн гэрчилгээжүүлэлт;

13.1.18.агаарын навигацийн техник үйлчилгээ, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ, хэрэглэлийн нислэгийн журам зохиох, нисэхийн цаг уурын болон нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт;

13.1.19.иргэний нисэхийн эдийн засгийн зохицуулалт;

13.1.20.олон улсын гэрээ, хууль тогтоомжид орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу батлах болон шаардлагатай бусад дүрэм.

13.2.Иргэний нисэхийн дүрэм нь үйл ажиллагаанд тохирсон, хэрэгжүүлэх боломжтой байхаар Конвенцын Хавсралтад нийцүүлэн боловсруулагдах бөгөөд тухай бүр шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулна.

14 дүгээр зүйл.Иргэний нисэхийн дүрмийн шаардлагаас чөлөөлөх

14.1.Тухайн дүрмээр хориглоогүй бөгөөд дараах нөхцөлийг зэрэг хангасан тохиолдолд иргэний нисэхийн дүрмийн шаардлагаас чөлөөлж болно:

14.1.1.хүсэлт гаргагч нь хүлээн зөвшөөрч болохуйц өөр хэлбэрээр дүрмийн шаардлагыг хангасан, эсхүл санал болгосон арга хэмжээ нь дүрмийн тухайн заалтыг хэрэгжүүлэхээс илүү үр дүнтэй;

14.1.2.нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй болох нь тогтоогдсон.

14.2.Иргэний нисэхийн дүрмийн шаардлагаас чөлөөлсөн тухай шийдвэрийг нийтэд мэдээлнэ.

14.3.Дүрмийн шаардлагаас чөлөөлөхдөө энэ хуулийн 13.1.2-д заасан дүрмийг баримтална.

15 дугаар зүйл.Иргэний нисэхийн аюулгүй байдлын зохицуулалт

15.1.Иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох болон зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, тэдгээрийг хэрэгжүүлэх замаар иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын зохицуулалтыг хэрэгжүүлнэ.

15.2.Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-ийн 5.9, 5.10, 5.11-т зааснаас бусад Монгол Улсын олон улсын гэрээ хэлэлцээрийн дагуу олгох иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага олгоно.

16 дугаар зүйл.Иргэний нисэхийн эдийн засгийн зохицуулалт

16.1.Иргэний нисэхийн эдийн засгийн зохицуулалтын дүрмээр дараах харилцааг зохицуулна:

16.1.1.олон улсын хуваарьт нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчийг томилох;

16.1.2.иргэний нисэхийн төлбөртэй үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээг тогтоох журам;

16.1.3.зорчигч, тээш, ачаа тээвэрлэлтийн ерөнхий нөхцөл;

16.1.4.агаарын тээвэрлэгчийн даатгал;

16.1.5.иргэний нисэхийн статистикийн мэдээлэл цуглуулах, түгээх;

16.1.6.иргэний нисэхийн салбарын хөрөнгө оруулалтын зардал, үр ашгийн тооцоо хийх;

16.1.7.агаарын навигаци, нисэх буудал болон агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хөрөнгө оруулалт, аюулгүй байдлыг хангах санхүүгийн чадавхад үнэлгээ хийх аргачлал;

16.1.8.хуульд заасан бусад.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ АГААРЫН ХӨЛӨГ, ТҮҮНД ХАМААРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

17 дугаар зүйл. Агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн бүртгэл

17.1.Төрийн захиргааны байгууллага Монгол Улсад бүртгэх агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн өмчлөлийг тодорхойлсон бүртгэлийг хөтөлнө.

17.2.Хувь хүн, хуулийн этгээд өөрийн өмчлөл, эсхүл эзэмшилд байгаа, бусад улсад бүртгэлгүй агаарын хөлгийг иргэний нисэхийн дүрмийн дагуу Монгол Улсад бүртгүүлнэ.

17.3.Бүртгэлгүй агаарын хөлгөөр Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэхийг хориглоно.

17.4.Энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийг зөрчсөн тохиолдолд агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгоно.

17.5.Агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ тухайн агаарын хөлгийн үндэсний харьяаллыг гэрчлэх ба агаарын хөлгийн өмчлөлийг нотлохгүй.

18 дугаар зүйл. Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар

18.1.Монгол Улсад төрийн захиргааны байгууллагаас олгосон, эсхүл хүлээн зөвшөөрсөн маягийн гэрчилгээтэй агаарын хөлгийг нислэгийн үйл ажиллагаанд ашиглана.

18.2.Маягийн гэрчилгээний шаардлага хангасан, үзлэг, шалгалтаар нислэгийн аюулгүй байдлыг хангах нөхцөлд байгаа агаарын хөлөгт нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгоно.

18.3.Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээнд түүний хүчинтэй хугацаа, агаарын хөлгийн зориулалт, нислэгийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай ангилал, хязгаарлалт болон бусад мэдээллийг оруулна.

18.4.Энэ хуулийн 18.2-т заасан “маягийн гэрчилгээ” гэж тухайн агаарын хөлгийн хийц нислэгт тэнцэх чадварын холбогдох шаардлагад нийцэж байгааг

Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагаас тодорхойлж олгосон баримт бичгийг ойлгоно.

19 дүгээр зүйл.Нислэгийн үйл ажиллагааны төрөл

19.1.Нислэгийн үйл ажиллагаа нь арилжааны агаарын тээвэр, агаараас гүйцэтгэх ажил болон ерөнхий зориулалтын нисэхийн төрөлтэй байна.

19.1.1.арилжааны агаарын тээврийн төрөлд зорчигч, ачаа, шууданг төлбөртэй тээвэрлэх, эсхүл эдийн засгийн үр шим хүртэх зорилгоор гүйцэтгэх нислэгийн үйл ажиллагаа хамаарна.

19.1.2.Агаараас гүйцэтгэх ажилд агаарын хөлгөөр гүйцэтгэх хөдөө аж ахуй, зураг авах, судалгаа, ажиглалт ба эргүүл хийх, эрэн хайх, авран туслах, зар сурталчилгаа болон нислэгээр гүйцэтгэх бусад ажил үйлчилгээ хамаарна.

19.1.3.арилжааны агаарын тээвэр болон агаараас гүйцэтгэх ажлаас бусад төрлийн нислэгийн үйл ажиллагаа ерөнхий зориулалтын нисэхэд хамаарна.

20 дугаар зүйл.Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ

20.1.Дарга Энэ хууль болон холбогдох иргэний нисэхийн дүрмийн шаардлага хангасан Монгол Улсын иргэнд агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг олгож болно.

20.2.Томилогдсон гадаадын агаарын тээвэрлэгч энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг хангасан нөхцөлд түүнд гадаадын агаарын тээвэрлэгчийн Монгол Улсын гэрчилгээ олгож болно.

20.3.Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг бусдад шилжүүлэхийг хориглоно.

21 дүгээр зүйл.Агаарын тээвэрлэгчийн үүрэг

21.1.Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй агаарын тээвэрлэгч дараах үүрэгтэй:

21.1.1.нислэгийн үйл ажиллагааг олгосон гэрчилгээ болон түүний үйл ажиллагааны тодорхойлолтод заасан эрх, хязгаарлалтын хүрээнд гүйцэтгэх;

21.1.2.үйлдвэрлэгчийн нислэгийн үйл ажиллагааны болон агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын шаардлага хангасан заавар, журам боловсруулж мөрдөх, холбогдох хууль тогтоомжийн дагуу нийтийн ашиг сонирхолд нийцсэн үйлчилгээ үзүүлэх;

22 дугаар зүйл.Агаарын хөлгийн дарга, түүний бүрэн эрх

22.1.Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь нислэгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор тухайн нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай үнэмлэх, гэрчилгээ бүхий нисгэгчийг агаарын хөлгийн даргаар томилно.

22.2.Агаарын хөлгийн дарга нислэгийн аюулгүй байдлыг хангах, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах зорилгоор нисгэх багийн гишүүд болон зорчигчид шаардлага тавьж, биелэлтийг хангуулах бөгөөд нислэгийн үйл ажиллагаатай холбоотой эцсийн шийдвэрийг гаргана.

22.3. Агаарын хөлгийн дарга иргэний нисэхийн дүрэмд зааснаас өөр шийдвэрийг дараах онцгой нөхцөлд гаргах эрхтэй:

22.3.1. хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд аюул тулгарсан бол;

22.3.2. өөрөөр шийдвэрлэх боломжгүй онцгой нөхцөлийг зохицуулах шаардлагатай бол.

22.4. Агаарын хөлгийн дарга Нислэгийн аюулгүй байдалд илт аюул тулгарсан тохиолдолд агаарын хөлөг болон түүний бүхээгт байгаа хүмүүсийн амь насыг аврах зорилгоор нислэгийн төлөвлөгөө болон нислэгийн хөдөлгөөний удирдагчийн өгснөөс өөр шийдвэр гаргаж болно.

22.5. Агаарын хөлгийн дарга хүний амь нас, эд хөрөнгийг хамгаалах зорилгоор эмнэлгийн болон бусад яаралтай тусламж хүргэх нислэгийг энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийг зөрчин гүйцэтгэж болно.

22.6. Гадаад улсын агаарын зайд нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн дарга албадан саатуулагдах нөхцөл байдалд орсон тохиолдолд тухайн улсын эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагыг дагаж мөрдөх үүрэгтэй.

23 дугаар зүйл. Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа

23.1. Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа нь чөлөөт нисэх, нисэх клуб болон хувийн нисэхийн үйл ажиллагаанаас бүрдэнэ.

23.2. Чөлөөт нисэхийн үйл ажиллагаанд шүхэр, агаарын бөмбөлөг, хүнгүй, хэт хөнгөн, хөнгөн агаарын хөлгөөр зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа хамаарна.

23.3. Чөлөөт нисэх, нисэх клуб, хувийн нислэгийн аюулгүй байдлыг агаарын хөлөг ашиглагч хариуцна.

23.4. Нисэх клуб болон хувийн нисэхийн үйл ажиллагааг зардал хуваах хэлбэрээр гүйцэтгэж болно.

23.5. Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаанд энэ хууль болон иргэний нисэхийн дүрмээс гадуур хязгаарлалт тогтоохыг хориглоно.

24 дүгээр зүйл. Нислэгийн үеийн дэг журам

24.1. Нисгэх багийн гишүүдээс өгсөн зааварчилгааг нислэгийн туршид дагаж мөрдөх үүрэгтэй.

24.2. Нисгэх багийн гишүүн нислэгийн үед аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй үйлдэл гаргасан, гаргахыг завдсан зорчигчийг аюулгүй болгох арга хэмжээ авна.

24.3. Дэг журам зөрчсөн зорчигчид авах арга хэмжээний журмыг Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

24.4. Агаарын тээвэрлэгч нислэгийн аюулгүй байдалд эрсдэл учруулахуйц дэг журам зөрчсөн, зөрчиж байсан зорчигчийг тээвэрлэхээс татгалзаж болно.

25 дугаар зүйл. Нислэгийн үйл ажиллагаанд хориглох зүйл

25.1.Нислэгийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

25.1.1.нислэгт тэнцэх чадварын шаардлага хангаагүй агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийг нислэгийн үйл ажиллагаанд ашиглах;

25.1.2.нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ нь хүчингүй болсон, эсхүл гэрчилгээний эрх, хязгаарлалтыг зөрчин агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэх;

25.1.3.агаарын тээвэрлэгчийн гэрчилгээгүй, эсхүл гэрчилгээний эрх, хязгаарлалт, энэ хууль болон иргэний нисэхийн дүрэм зөрчин нислэгийн үйл ажиллагаа эрхлэх;

25.1.4.агаарын хөлөгт гарал үүсэл тодорхойгүй, үйлдвэрлэгчийн техникийн тодорхойлолтод нийцээгүй эд анги ашиглах;

25.1.5.иргэний нисэхийн дүрмийн хязгаарлалтыг зөрчин нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа агаарын хөлөг, түүний бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийх;

25.1.6.агаарын хөлөгтэй холбоотой ажил, үйлчилгээнд нисэхийн мэргэшсэн ажилтны үнэмлэх, гэрчилгээгүй этгээдийг ажиллуулах, гэрчилгээгээр олгосон эрхээс хэтэрсэн ажил үүрэг гүйцэтгүүлэх;

25.1.7.нисгэх багийн гишүүдээс бусад этгээд нислэгийн үед агаарын хөлгийн даргын зөвшөөрөлгүйгээр нисгэх багийн бүхээгт нэвтрэх.

25.1.8.бүрэн бус бүрэлдэхүүнтэй нисэх баг нислэг үйлдэхийг хориглоно.

26 дугаар зүйл.Зөрчил гаргасан агаарын хөлөг

26.1.Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх болон улсын хилийг агаарын орох, гарах цэгээр нэвтрэн өнгөрөх журмыг зөрчсөн, түүнчлэн эрх бүхий байгууллагын зохих зөвшөөрөлгүй улсын хил нэвтэрсэн агаарын хөлгийг зөрчил гаргасан агаарын хөлөг гэж үзнэ.

26.2.Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага энэ хуулийн 26.1-д заасан агаарын хөлгийн тухай Монгол Улсын агаарын зайн аюулгүй байдлыг хангах эрх бүхий байгууллагад мэдэгдэж, агаарын хөлгийн нисгэх багт зөрчлөө нэн даруй зогсоох, заасан газар хөлгөө буулгах шаардлага тавина.

26.3.Албадан саатуулж буй агаарын хөлөгт зэвсэг хэрэглэхийг хориглоно.

27 дугаар зүйл.Аюул тулгарсан агаарын хөлөг

27.1.Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага Монгол Улсын нутаг дэвсгэрт аюул тулгарсан агаарын хөлгийн талаар зохих журмын дагуу холбогдох байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

27.2.Чикагогийн конвенцын 25 дугаар зүйлийн дагуу аюул тулгарсан агаарын хөлгийг эрэн хайх, авран туслах үйл ажиллагааг Улсын онцгой комисс тухайн агаарын хөлгийг эзэмшигч, эсхүл бүртгэгч улсын эрх бүхий байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

27.3.Хувь хүн, хуулийн этгээд нь аюул тулгарсан агаарын хөлгийн талаар холбогдох байгууллагад нэн даруй мэдээлэх, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, эмнэлгийн болон бусад зайлшгүй шаардлагатай тусламж үзүүлэх үүрэгтэй.

28 дугаар зүйл. Агаарын тээвэрлэгчийн даатгал

28.1. Агаарын тээвэрлэгч зорчигчийн амь нас, эрүүл мэнд, ачаа, тээш, шуудан, эд хөрөнгөнд учрах хохирлыг барагдуулах хариуцлагын даатгалтай байна.

28.2. Агаарын тээвэрлэгч албан үүргээ гүйцэтгэж байгаа нисгэх багийн гишүүдийн амь нас, эрүүл мэндийг заавал даатгуулна.

28.3. Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх агаарын хөлөг гуравдагч этгээдэд учрах хохирлыг хариуцах баталгаа бүхий даатгалтай байна.

ТАВДУГААР БҮЛЭГ АГААРЫН НАВИГАЦИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

29 дүгээр зүйл. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага

29.1. Монгол Улсын агаарын зайд агаарын навигацийн үйлчилгээг иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн төрийн өмчит хуулийн этгээд /цаашид “агаарын навигацийн үйлчилгээний байгууллага” гэх/ Монгол Улсын нэрийн өмнөөс үзүүлнэ.

29.2. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага нь энэ хуулийн 29.1-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх чадамж бүхий хүний нөөцтэй байна.

29.3. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага нь нислэгийн хөдөлгөөнийг аюулгүй, үр ашигтай удирдан, зохион байгуулахад чиглэсэн нислэгийн хөдөлгөөний менежментийг хэрэгжүүлнэ.

30 дугаар зүйл. Нислэгийн хөдөлгөөний зохицуулалт

30.1. Агаарын хөлөг нь Монгол Улсын агаарын зайг тогтоосон орох, гарах цэгээр нэвтэрч, нислэг үйлдэнэ.

30.2. Агаарын зайн ангилал, бүтэц, зохион байгуулалт, агаарын хөлгийн хоорондын аюулгүйн зайчлал нь Конвенцын Хавсралтын стандарт, журмын шаардлагад нийцсэн байна.

30.3. Нислэгийн хөдөлгөөний хяналттай агаарын зай нь нислэгийн аюулгүй байдал, Конвенцын Хавсралтын стандарт, журмын шаардлагад нийцсэн агаарын навигацийн байгууламжаар тоноглогдсон байна.

31 дүгээр зүйл. Агаарын навигацийн үйл ажиллагааны санхүүжилт

31.1. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага нь агаарын зам, нисэх буудлыг Конвенцын Хавсралтын стандартын суурь түвшнийг хангасан агаарын навигацийн үйлчилгээ, агаарын навигацийн тоног төхөөрөмж, байгууламжаар хангахад тусгайлан зориулах агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн орлогоос санхүүжнэ.

31.2. Агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн орлого нь агаарын навигацийн үйлчилгээг аюулгүй, тасралтгүй үзүүлэх, Конвенцын Хавсралтын стандартын суурь түвшнийг хангахад хүрэлцэхгүй тохиолдолд үйл ажиллагааг хэвийн явагдах хэмжээнд төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ АЭРОДРОМ, НИСЭХ БУУДАЛ

32 дугаар зүйл. Аэродром

32.1. Монгол Улсын иргэн, хуулийн этгээд иргэний нисэхийн дүрмийн дагуу аэродром байгуулна.

32.2. Агаарын тээврийн үйл ажиллагаанд тогтмол ашиглагдах аэродром нь иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн байна.

32.3. Нисэхийн мэдээллийн эмхэтгэлд нийтэд үйлчлэхээр зарласан аэродром нь нислэгийн аюулгүй байдлыг хангах бодит шаардлагаас бусад үед агаарын хөлөгт үйлчилгээ үзүүлэхээс татгалзахыг хориглоно.

32.4. Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь Конвенцын Хавсралтын стандартын суурь түвшинд нийцсэн, үйл ажиллагаандаа тохирсон төхөөрөмжөөр тухайн аэродромыг тоноглох үүрэгтэй.

33 дугаар зүйл. Нисэх буудал

33.1. Нисэх буудал гэж аэродром, агаарын тээврийн үйлчилгээний барилга, байгууламжийн цогцолборыг ойлгоно.

33.2. Нисэх буудал нь олон улсын болон орон нутгийн нислэгт нисэхийн аюулгүйн хамгаалалт, аэродром, нисэхийн хангамж, газрын үйлчилгээ болон бусад нисэхийн ба нисэхийн бус үйлчилгээ үзүүлж болно.

33.3. Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь нисэх буудлыг хөгжүүлэх төлөвлөгөөг тухайн хот, аймаг, сумын нутгийн захиргааны байгууллагатай зөвшилцөн төлөвлөнө.

34 дүгээр зүйл. Аэродромын аюулгүйн бүс

34.1. Аэродром орчмын аюулгүйн бүсийг аэродромын техник, технологийн баримт бичигт заасны дагуу тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.

34.2. Аэродром орчмын аюулгүйн бүсэд нислэгийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх жагсаалт, барилга байгууламжийн өндрийн хязгаарлалтыг аэродромын техник, технологийн баримт бичигт зааснаар зохицуулна.

35 дугаар зүйл. Дохио, тэмдэг

35.1. Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь аэродром, түүний орчимд агаарын хөлөг хөөрөх, буух, явгалах үед агаарын хөлгийн чиг баримжаа тогтооход зориулсан аэродромын тэмдэг, тэмдэгт, тэмдэглэгээ, гэрэл дохиоллыг аэродромын техник, технологийн баримт бичигт зааснаар байрлуулж, ашиглана.

35.2.Аэродромын аюулгүйн бүсэд барилга байгууламж өмчлөгч, эсхүл эзэмшигч агаарын хөлгийн нислэгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор уг барилга байгууламж дээр аюулгүй байдлыг хангах саадын дохио, тэмдэглэгээг аэродромын техник, технологийн баримт бичигт заасны дагуу байрлуулна.

35.3.Аэродромын аюулгүйн бүсэд агаарын хөлгийн чиг баримжаа тогтооход зориулсан аюулгүй байдлын дохио, тэмдэглэгээтэй ижил төстэй зүйл байрлуулахыг хориглоно.

ДОЛООДУГААР БҮЛЭГ НИСЭХИЙН АЮУЛГҮЙН ХАМГААЛАЛТ

36 дугаар зүйл.Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ

36.1.Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ нь аюулгүйн үзлэг, шалгалт болон нисэх буудал, агаарын навигацийн байгууламжийн харуул хамгаалалтын үйлчилгээнээс бүрдэнэ.

36.2. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээг иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн төрийн өмчит хуулийн этгээд гүйцэтгэнэ.

36.3.Нисэхийн аюулгүйн хамгаалалтын байгууллага нь аюулгүйн хамгаалалттай холбоотой хууль, дүрмийг зөрчсөн этгээдийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх зорилгоор саатуулах эрхтэй.

37 дугаар зүйл.Аюулгүйн үзлэг, шалгалт

37.1.Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага нь дараах аюулгүйн үзлэг, шалгалт хийнэ. Үүнд:

37.1.1.аюулгүйн хамгаалалт шаардлагатай нисэх буудал, аэродромд нисгэх багийн гишүүн, зорчигч, бусад нэвтрэн орох этгээд, тээш, ачаа, шуудан, нислэгийн хоол хүнс болон хангамжийн эд зүйлд;

37.1.2.өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд болон түүнд нэвтрэхээс өмнө хүн, тэдгээрийн авч яваа эд зүйлс болон тээврийн хэрэгсэлд.

37.2.Зорчигч аюулгүйн үзлэг, шалгалт хийлгэхээс татгалзсан тохиолдолд агаарын хөлгөөр тээвэрлэх гэрээг тухайн агаарын тээвэрлэгч цуцалж болно.

37.3.Энэ хуулийн дагуу гүйцэтгэж байгаа аюулгүйн үзлэг, шалгалт хийлгэхээс татгалзсан этгээдийг нисэхийн аюулгүйн хамгаалалтын бүсэд нэвтрэхийг хориглоно.

38 дугаар зүйл. Нисэх буудал, агаарын навигацийн байгууламжийн хамгаалалт

38.1.Олон улсын нислэгт үйлчилдэг нисэх буудал болон агаарын навигацийн байгууламж нь нисэхийн аюулгүйн хамгаалалтын байгууллагын хамгаалалтад байна

НАЙМДУГААР БҮЛЭГ ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТ

39 дүгээр зүйл.Иргэний нисэхийн хяналт

39.1.Иргэний нисэхийн хяналт нь нислэгийн аюулгүй байдал, нисэхийн аюулгүйн хамгаалалт болон иргэний нисэхийн үйлчилгээний дараах хяналтаас бүрдэнэ.

39.1.1.иргэний нисэхийн мэргэшсэн ажилтны үнэмлэх, гэрчилгээжүүлэлт;

39.1.2.нислэгийн үйл ажиллагааны стандарт;

39.1.3.нислэгт тэнцэх чадвар.

39.1.4.агаарын тээврийн үйлчилгээ;

39.1.5.агаарын навигацийн үйлчилгээ;

39.1.6.нисэх буудал, аэродромын үйлчилгээ;

39.1.7.аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ.

40 дүгээр зүйл.Иргэний нисэхийн хяналтын байцаагч

40.1.Энэ хуулийн 37 дугаар зүйлд заасан хяналтыг иргэний нисэхийн хяналтын байцаагч /цаашид “байцаагч” гэх/ хэрэгжүүлнэ.

40.2.Байцаагч нь тухайн хяналтын чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан, мэргэжил бүхий, мэргэшсэн, холбогдох хууль тогтоомж, иргэний нисэхийн олон улсын эрх зүйн зохицуулалтын талаар шалгуулах этгээдээс илүү мэдлэг, дадлага туршлага, ур чадвартай байна.

40.3.Байцаагч өөрийн гаргасан шийдвэр, дүгнэлт, шаардлага, нотолгооны үнэн зөвийг бүрэн хариуцна.

41 дүгээр зүйл.Байцаагчийн бүрэн эрх

41.1.Байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхтэй:

41.1.1.агаарын хөлөг нь нислэгт тэнцэх чадвартай бөгөөд нислэгийн үйл ажиллагаа нь энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн шаардлага хангаж байгаа эсэхийг тогтоох үзлэг шалгалт хийх зорилгоор Монгол Улсад нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлөгт саадгүй нэвтрэх;

41.1.2.аль улсад нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаагаас үл хамааран, агаарын хөлөг нь нислэгт тэнцэх чадвартай бөгөөд нислэгийн үйл ажиллагаа нь энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн шаардлага хангаж байгаа эсэхийг тогтоох үзлэг шалгалт хийх зорилгоор Монгол Улсын бүртгэлтэй, эсхүл Монгол Улсын агаарын тээвэрлэгчийн ашиглаж байгаа агаарын хөлөгт саадгүй нэвтрэх;

41.1.3.энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн шаардлагын хэрэгжилтэд үзлэг шалгалт хийх зорилгоор иргэний нисэхийн дараах байгууламжид аль ч үед саадгүй нэвтрэх:

- 41.1.3.1.агаарын тээвэрлэгчийн ажлын байр;
- 41.1.3.2.агаарын хөлгийн эзэмшигчийн ажлын байр;
- 41.1.3.3.ангар, агуулах байр;
- 41.1.3.4.техник үйлчилгээний байгууллага;
- 41.1.3.5.засвар, үйлчилгээний газар;
- 41.1.3.6.агаарын хөлгийн зогсоол;
- 41.1.3.7.аэродром, нисэх буудлын байгууламж;
- 41.1.3.8.агаарын навигацийн байгууламж;
- 41.1.3.9.шатахуун хадгалах, түгээх байгууламж;
- 41.1.3.9.ачааны байгууламж;
- 41.1.3.11.нисэхийн сургалтын байгууллага.

41.1.4.иргэний нисэхийн үйл ажиллагаатай холбогдол бүхий хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, дуу, дүрс, бичлэг бусад баримт бичгийг холбогдох хувь хүн, хуулийн этгээдээс гаргуулан авах;

41.1.5.агаарын хөлөг нислэгт тэнцэх чадваргүй, эсхүл нислэгийн үйл ажиллагаа нь хүн болон эд хөрөнгөнд хохирол учруулж болзошгүй тохиолдолд тухайн нөхцөл арилах хүртэл агаарын хөлгийг саатуулах;

41.1.6.шаардлагатай дуу, дүрсний бичлэг хийх, баримтжуулах үйл ажиллагааг зохион байгуулах;

41.1.7.нисэхийн аюулгүйн хамгаалалтын сорилт хийх;

41.1.8.хуульд заасан бусад.

42 дугаар зүйл. Байцаагчийн ажиллах нөхцөл, баталгаа.

42.1. Олон улсын гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор байцаагчийн цалин хөлсийг иргэний нисэхийн салбарын дундаж цалингаас багагүйгээр тогтоох ба шаардлагатай тохиолдолд нэмэгдэл хөлс олгож болно.

42.2.Байцаагчид ажилласан гурван жил тутам 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгоно;

42.3.Байцаагчид тавигдах шаардлага, байцаагчийг сонгон шалгаруулах, мэргэшүүлэх, нийгмийн баталгааг хангах, урамшуулах журмыг Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

42.4.Байцаагч нь түүний эрхийн хүрээг тодорхой заасан үнэмлэхтэй байна.

42.5.Байцаагч нь дүрэмт хувцас болон үзлэг шалгалт хийхэд шаардлагатай тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслээр хангагдсан байна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ

43 дугаар зүйл.Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа

43.1.Агаарын хөлөг эзэмшигч, иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч, агаарын хөлгийн дарга, нисгэх багийн гишүүд, аэродром болон агаарын навигацийн үйлчилгээний байгууллагын ажилтан агаарын хөлгийн осол, зөрчлийн талаарх анхан шатны мэдээллийг нэн даруй, боломжит хэлбэрээр өгөх, дэлгэрэнгүй мэдээллийг холбогдох дүрэмд заасан хугацаанд өгөх үүрэгтэй.

43.2.Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага ослын мэдээллийг хүлээн авмагц шинжлэн шалгах ажиллагааг нэн даруй эхлүүлнэ.

43.3.Осол, зөрчилд өртсөн агаарын хөлөгтэй холбоотой эд мөрийн баримтыг агаарын хөлөг эзэмшигч болон холбогдох бусад этгээд шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэж дуусах хүртэл хадгалж, хамгаална.

43.4.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр агаарын хөлгийн осол, зөрчил гарсан үед иргэн, нутгийн захиргааны байгууллага, онцгой байдлын газар, цагдаа болон зэвсэгт хүчний анги салбар агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагад үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах туслалцааг цаг тухайд нь үзүүлэх үүрэгтэй.

44 дүгээр зүйл.Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны зарчим

44.1.Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа нь осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилготой ба аливаа этгээдийн гэм бурууг тогтоох зорилгогүй.

44.2.Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа нь хараат бус, бие даасан байна.

44.3.Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шаардлагатай гэж үзвэл шинжлэн шалгах ажиллагааг агаарын хөлөг бүртгэгч улс, агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ олгогч улс, агаарын хөлөг үйлдвэрлэгч улс, бүс нутгийн нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагад хэсэгчлэн болон бүрэн шилжүүлж болно.

45 дугаар зүйл.Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага

45.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт гарсан агаарын хөлгийн осол, зөрчлийг Конвенцын Хавсралт 13-ын дагуу шинжлэн шалгах, ангилах, бүртгэх ажиллагааг агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага гүйцэтгэнэ.

45.2.Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүтцэд байна.

45.3.Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг тус улсын нутаг дэвсгэрийн гадна осол, ноцтой зөрчилд өртсөн үед шинжлэн шалгах ажиллагааг олон улсын хэлэлцээрийн дагуу гүйцэтгэх ба Монгол Улсын нэрийн өмнөөс агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага оролцож болно.

45.4.Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага агаарын хөлгийн осол, зөрчилтэй холбоотой мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөл, нөлөөлсөн хүчин зүйлсийн талаар тайлан гаргана.

45.5.Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага нислэгийн аюулгүй байдлыг сайжруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор шинжлэн шалгах ажиллагааны аль ч үе шатанд аюулгүй байдлын зөвлөмж гаргаж болно.

45.6.Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага албан үүргээ гүйцэтгэсэнтэй нь холбогдуулан аливаа этгээдийн гэм бурууг тогтоох зорилгоор захиргааны болон иргэн, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон шүүн таслах ажиллагаанд гэрчээр оролцуулахыг хориглоно.

45.7.Шинжлэн шалгах баг осол гарсан газарт ажиллах үед шаардлагатай хамгаалах хувцас хэрэгсэл, төхөөрөмж болон холбоо, тээврийн хэрэгслээр хангагдсан байна.

46 дугаар зүйл.Ерөнхий шинжлэн шалгагч, түүний бүрэн эрх

46.1.Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагыг Ерөнхий шинжлэн шалгагч удирдана.

46.2.Ерөнхий шинжлэн шалгагч шинжлэн шалгах чиглэлээр мэргэшсэн, холбогдох хууль, иргэний нисэхийн дүрэм, заавар, иргэний нисэхийн талаарх олон улсын эрх зүйн зохицуулалтын талаар зохих мэдлэгтэй, Монгол Улсын иргэн байна.

46.3.Ерөнхий шинжлэн шалгагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

46.3.1.агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагын ажилтан, шинжлэн шалгагчийг томилох, чөлөөлөх;

46.3.2.агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах багийн ахлагч болон гишүүдийг томилох;

46.3.3.агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааг зохион байгуулах;

46.3.4.ослын газрыг хамгаалалтад авах асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

46.3.5.шинжлэн шалгах ажиллагааны эцсийн тайланг батлах;

46.3.6.агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны төсвийг хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах;

46.3.7. шинжлэн шалгах ажиллагаанд мөрдөх дотоод үйл ажиллагааны заавар, журмыг батлах.

47 дугаар зүйл. Шинжлэн шалгагч, түүний бүрэн эрх

47.1. Шинжлэн шалгагч нь агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэхтэй нисгэгч, агаарын навигацийн болон агаарын хөлгийн инженер эсхүл шинжлэн шалгах чиглэлээр мэргэшсэн нисэхийн бусад мэргэжилтэй байна.

47.2. Шинжлэн шалгагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

47.2.1. албан үүргээ гүйцэтгэхдээ агаарын хөлгийн осол, зөрчилтэй холбоотой барилга байгууламжид ямар ч үед саадгүй нэвтрэх, холбогдох нотлох баримтыг гаргуулах;

47.2.2. шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагатай мэдээ, судалгаа, тодорхойлолт болон бусад нотлох баримтыг холбогдох хувь хүн, хуулийн этгээдээс шаардан авах;

47.2.3. ерөнхий шинжлэн шалгагчаас олгосон бусад эрх.

48 дугаар зүйл. Шинжлэн шалгах багийн ахлагч, түүний бүрэн эрх

48.1. Шинжлэн шалгах багийн ахлагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

48.1.1. агаарын хөлгийн осол, зөрчил гарсан газарт ямар ч үед саадгүй нэвтрэх, шинжлэн шалгах ажиллагаанд хамааралтай ослын үлдэгдэл, бүх төрлийн эд зүйлст хяналтаа тогтоох;

48.1.2. нислэгийн бичлэгийн төхөөрөмж, тухайн нислэгийн үйл ажиллагаатай холбоотой агаарын навигацийн үйлчилгээний бичлэгүүд зэрэг бусад нотлох баримтыг өөрийн хяналтад авах;

48.1.3. шинжлэн шалгах ажиллагааг цаг алдалгүй эхлүүлэх зорилгоор холбогдох эд мөрийн баримт, агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн үлдэгдлийг өөрийн хяналтад авах;

48.1.4. шинжлэн шалгах ажиллагааны явцад эд мөрийн баримтыг хамгаалах, агаарын хөлөг, түүний үлдэгдэл байгаа бүсэд зөвшөөрөлгүй этгээд нэвтрэх, эд зүйл үрэгдэж гэмтэх, алдагдахаас хамгаалах боломжит бүх арга хэмжээг авах;

48.1.5. ослын газрыг хамгаалалтад авах зорилгоор эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх;

48.1.6. шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай ажиглагч, оролцогчийг томилж;

48.1.7. шинжлэн шалгах ажиллагааны явцыг ерөнхий шинжлэн шалгагчид танилцуулах, ослын боломжит шалтгаан, нөлөөлсөн байж болох хүчин зүйлд тулгуурлан аюулгүй байдлын зөвлөмж гаргах ажиллагааг зохион байгуулах;

48.1.8. ослын газрын хамгаалалтыг буулгах, шинжлэн шалгах ажиллагаанд цаашид шаардлагагүй болсон агаарын хөлөг, түүний бүрдэл хэсэг, эд зүйлсийг хадгалалтаас чөлөөлөх;

48.1.9.шинжлэн шалгах ажиллагааны тайланг гаргах;

48.1.10.хуульд заасан бусад.

49 дүгээр зүйл.Шинжлэн шалгах ажиллагааны тайлан

49.1.Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага эцсийн тайланг гаргахаас өмнө тухайн осол, зөрчлийн шинжлэн шалгах ажиллагаанд хамааралтай байгууллага, хамтран оролцсон улс болон эрх бүхий байгууллагаас санал авахаар тайлангийн төслийг хүргүүлнэ.

49.2.Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага агаарын хөлгийн осол, зөрчил давтан гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор шинжлэн шалгах ажиллагааны тайланг боломжит богино хугацаанд гаргана.

49.3.Агаарын хөлгийн осол, зөрчлийн шинжлэн шалгах ажиллагааны тайлан болон аюулгүй байдлын зөвлөмжийг аливаа этгээдийн гэм бурууг тогтоох зорилгоор захиргааны хариуцлага хүлээлгэх, хянан шийдвэрлэх болон шүүн таслах ажиллагаанд нотлох баримтаар ашиглахгүй.

50 дугаар зүйл.Аюулгүй байдлын зөвлөмж

50.1.Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага нислэгийн аюулгүй байдлыг сайжруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор шинжлэн шалгах ажиллагааны аль ч үе шатанд аюулгүй байдлын зөвлөмж гаргаж болно.

50.2.Аюулгүй байдлын зөвлөмжийг агаарын хөлөг үйлдвэрлэгч, төрийн захиргааны байгууллага, агаарын тээвэрлэгч болон бусад холбогдох байгууллагад, шаардлагатай бол Олон улсын иргэний нисэхийн байгууллагад хүргүүлнэ.

50.3.Аюулгүй байдлын зөвлөмжийг хүлээн авсан этгээд зөвлөмжийн дагуу шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн 90 хоногийн дотор эргэж мэдэгдэнэ. Хэрэгжүүлэх боломжгүй бол үндэслэл бүхий тайлбараа гаргаж хүргүүлнэ.

50.4.Энэ хуулийн 48.3-т заасан этгээд аюулгүй байдлын зөвлөмжийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь хүлээн зөвшөөрөхгүй байх бодит үндэслэл байгаа бол тайлбарыг агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагад нэн даруй хүргүүлнэ.

50.5.Аюулгүй байдлын зөвлөмжийг хүлээн авсан этгээд зөвлөмжийн дагуу хэлэлцэж, үндэслэлтэй гэж үзвэл хэрэгжүүлэх арга хэмжээний талаар 90 хоногийн дотор эргэж мэдэгдэх үүрэгтэй.

51 дүгээр зүйл.Шинжлэн шалгах ажиллагааг сэргээх

51.1.Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны эцсийн тайлан гарсны дараа тайлангийн дүгнэлтийг өөрчилж болох баримт, нөхцөл байдал шинээр илэрсэн бол агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага шинжлэн шалгах ажиллагааг сэргээнэ.

АРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

52 дугаар зүйл.Үйл ажиллагааны санхүүжилт

52.1.Иргэний нисэхийн хяналт, зохицуулалт, агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалт, агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа нь олон улсын гэрээний хэрэгжилтийг хангахуйц санхүүгийн чадавхтай байна.

52.2.Иргэний нисэхийн хяналт, зохицуулалт, агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалт, агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах, төрийн өмчит аэродром, нисэх буудал, агаарын навигацгийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааны зардлыг улсын төсөв болон агаарын навигацгийн хураамжийн орлогоос санхүүжүүлнэ.

52.3.Агаарын навигацгийн үйлчилгээний хураамжийн орлогын хориос доошгүй хувийг иргэний нисэхийн хяналт, зохицуулалт, агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалт, агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах үйл ажиллагаанд зарцуулна.

53 дугаар зүйл.Иргэний нисэхэд ашиглах хэл

53.1.Иргэний нисэхэд ашиглах техник, технологийн баримт бичгийг монгол, англи хэл дээр хэрэглэж болно.

53.2.Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээг англи хэл дээр үзүүлж болно.

54 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

54.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

54.2.Энэ хуулийг зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

55 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

55.1.Энэ хуулийг 2024 оны дугаар сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

